

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Захирлын 2023 оны 2 дугаар сарын
08-ны өдрийн А/37 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” ХУУЛЬ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛИЙГ ЭРХЛЭН ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Хууль зүйн үндэсний хүрээлэн /цаашид “хүрээлэн” гэх/-гийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүл /цаашид “сэтгүүл” гэх/-ийг эрхлэн гаргахтай холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2. Сэтгүүл нь хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн мэргэжлийн улирал тутмын хэвлэл байх бөгөөд монгол хэлээр “Хууль дээдлэх ёс”, англи хэлээр “Mongolian Journal of Law” гэсэн нэртэй байна.
- 1.3. Сэтгүүлийн үүсгэн байгуулагч нь хүрээлэн байх бөгөөд сэтгүүлийн нэрийг эзэмших эрх үүсгэн байгуулагчид хадгалагдана. Сэтгүүлийн үйл ажиллагаа ашгийн төлөө бус байна.
- 1.4. Сэтгүүл нь хүрээлэнгийн өмч бөгөөд олон улсын стандартын сериал дугаар буюу ISSN (*International Standard Serial Number*) бүртгэлээр баталгаажсан бөгөөд Оюуны өмчийн газрын барааны тэмдгийг эзэмших онцгой эрхтэй болно.
- 1.5. Сэтгүүл нь цахим шуудангийн хаягтай байх ба цахим шуудангийн хаяг нь сэтгүүлийн оноосон нэрийг агуулсан байна. Сэтгүүл нь цахим сүлжээнд хуудастай байж болно. Сэтгүүлийн албан ёсны хаяг нь хүрээлэнгийн хаяг байна.

Хоёр. Нийтлэлийн бодлого, эрхэм зорилго

- 2.1. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь хууль зүйн шинжлэх ухааны ололтыг түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэнэ.
- 2.2. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээл тус бүрд хянан магадлагаа (англ. *a Peer Review*) хийх бөгөөд хянан магадлагааг хараат бусаар хийж, үр дүнг зохиогчид тодорхой мэдээлнэ.
- 2.3. Сэтгүүлийн хянан магадлагааны явцад бүтээлийн зохиогч болон хянан магадлагч сэтгүүлийн зөвлөлийн гишүүний мэдээллийг харилцан нууцалсан (англ. *Double-blind peer-review*) байна.
- 2.4. Сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлд Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг болон Хууль зүйн их, дээд сургуулийн магистр, докторын сургалтын хөтөлбөрт эрдэм шинжилгээний багц цаг тооцно.
- 2.5. Сэтгүүлд нийтэлсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч бөгөөд бүтээл ашиглах онцгой эрх нь хууль тогтоомжоор хамгаалагдана. Зохиогч

бүтээлээ нийтлүүлэхээр ирүүлснээр бүтээлийг нийтлэх, нийтэд түгээх эрхийг сэтгүүлд олгохыг зөвшөөрсөн гэж үзнэ.

- 2.6. Мэргэжлийн хянан магадлагаа бүхий сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэх нь эрдэмтэн, судлаач, хууль зүйн их, дээд сургуульд суралцагсдын хувьд нэр төрийн хэрэг бөгөөд сэтгүүлийн шалгуур, бүтээлд тавих шаардлагыг баримталж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зохих ангилал, зэрэглэлтэй сэтгүүл болох нь сэтгүүлийн эрхэм зорилго мөн.

Гурав. Сэтгүүлийн удирдлага, зохион байгуулалт

- 3.1. **Сэтгүүлийн удирдлагыг Сэтгүүлийн зөвлөл хэрэгжүүлнэ. Сэтгүүлийн зөвлөл нь нийтлэлийн бодлогыг тодорхойлох** санал, шүүмж өгөх, бүтээлийн чанарт хяналт тавих, дээшлүүлэх болон үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
- 3.2. Сэтгүүлийн зөвлөл нь ерөнхий эрхлэгч, эрхлэгч, гишүүдээс бүрдсэн 30 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна. Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүн нь хууль зүйн докторын зэрэгтэй эсхүл салбартаа 10-аас дээш жил ажилласан туршлагатай, тодорхой салбар эрх зүйгээр өндөр мэргэшсэн, олон улсад болон дотоотод нэр хүнд бүхий эрдэмтдээс бүрдэнэ. Сэтгүүлийн зөвлөл нь сайн дурын үндсэн дээр ажиллана.
- 3.3. Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч нь хүрээлэнгийн Захирал, эрхлэгч нь Эрдэмтэн нарийн бичгийн дарга байна.
- 3.4. Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг сэтгүүлийн эрхлэгчийн саналыг харгалзан хүрээлэнгийн захирал буюу ерөнхий эрхлэгчийн тушаалаар 3 жилийн хугацаатайгаар батална. Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүний идэвх оролцоог харгалзан улируулан томилох эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.
- 3.5. Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч нь дараах бүрэн эрхтэй:
- 3.5.1. Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх;
 - 3.5.2. Сэтгүүлийн эрхлэгчийг томилох, чөлөөлөх;
 - 3.5.3. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого, эрхэм зорилгыг батлах;
 - 3.5.4. Сэтгүүлийн зөвлөлийн хуралдааныг зарлах, даргалах;
 - 3.5.5. Сэтгүүлд нийтлэл хүлээн авах хугацааг жил тутамд батлах;
 - 3.5.6. Хянан магадлагааны хураамжийг батлах, өөрчлөх;
 - 3.5.7 Энэ журмын 3.7.3-т заасан хянан магадлагааг үндэслэн тухайн дугаарт хэвлэх нийтлэлийн жагсаалтыг батлах болон журамд заасан бусад бүрэн эрх.
- 3.6. Сэтгүүлийн эрхлэгч нь дараах бүрэн эрхтэй:
- 3.6.1. Сэтгүүлийн зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлсон саналаа сэтгүүлийн ерөнхий эрхлэгчид танилцуулах;
 - 3.6.2. Сэтгүүлд ирүүлсэн нийтлэлийг сэтгүүлийн зөвлөлийн гишүүдэд мэргэшсэн чиглэлийг нь харгалзан хянан магадлагаа хийлгэхээр хуваарилах ба хянан магадлагааг хараат бусаар хийх боломжоор хангах;

3.6.3. Сэтгүүлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах, сэтгүүлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаанд хяналт тавих болон журамд заасан бусад бүрэн эрх.

3.7. Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн нь дараах бүрэн эрхтэй:

3.7.1. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого, эрхэм зорилгыг тодорхойлоход санал өгөх;

3.7.2. Сэтгүүлийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.7.3. Мэргэшсэн чиглэлийнхээ хүрээнд заасан хугацаанд бүтээлд хянан магадлагаа хийж, санал, дүгнэлт гаргах, мэргэжлийн түвшинд зөвлөгөө өгөх;

3.7.4. Сэтгүүлийн үйл ажиллагааг дээшлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

3.7.5. Сэтгүүлд өөрийн бүтээлээ хянан магадлагаагүйгээр нийтлүүлэх;

3.7.6. Хянан магадлагаа хийсэн нийтлэлийн тоонд нийцүүлэн хянан магадлагааны хураамжийг урамшуулал болгон авах.

3.8. Сэтгүүлийн зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр хуралдаан байна. Зөвлөлийн хуралдааныг сэтгүүлийн ерөнхий эрхлэгч зарлан хуралдуулна.

3.9. Сэтгүүл нь сэтгүүлд нийтлэх бүтээлийг хүлээн авах, хэвлэлд бэлтгэх зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ажлын албатай байна.

3.10. Сэтгүүлийн ажлын алба нь эрхлэгч, хариуцлагатай нарийн бичгийн дарга, хэвлэлийн эх бэлтгэгчээс бүрдэх бөгөөд сэтгүүлийн нарийн бичгийн даргыг хүрээлэнгийн эрхлэгчийн саналыг харгалзан ерөнхий эрхлэгчийн тушаалаар Эрдэм шинжилгээний ажилтныг томилно.

3.11. Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга нийтлэл хүлээн авах, журамд заасан шаардлагыг хангуулах, хэвлэлд бэлтгэх, сурталчлах зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг хийж гүйцэтгэх бөгөөд сэтгүүлийн эрхлэгчид ажлаа тайлагнана.

3.12. Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.12.1. Сэтгүүлд ирүүлсэн нийтлэлийг хүлээн авах, хэлбэрийн шаардлага хангуулах;

3.12.2. Хэлбэрийн шаардлага хангаагүй нийтлэлийг буцаах;

3.12.3. Сэтгүүлийн зөвлөлийн гишүүдэд хуваарилсан нийтлэлийг хүргүүлэх, ирүүлсэн хянан магадлагааны дагуу зохиогчид хариу мэдээлэх;

3.12.4. Сэтгүүлийн үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангах;

3.12.5. Сэтгүүлийг хэвлэлд бэлтгэх, хэлбэрийн шаардлага, хэл зүйн алдааг нягтлах;

3.12.6. Сэтгүүлийн цахим шуудан болон цахим сүлжээн дэх хуудсыг хөтлөж, сэтгүүлийг сурталчлах ажиллагааг хариуцах;

3.12.7. Сэтгүүлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг сэтгүүлийн эрхлэгчид тайлагнах;

3.12.8. Сэтгүүлийн талаарх үнэн зөв мэдээллийг холбогдох этгээдэд өгөх болон журамд заасан бусад эрх, үүрэг.

Дөрөв. Сэтгүүлд нийтлэх бүтээлд тавих шаардлага

- 4.1. Сэтгүүлд олон улсын болон үндэсний эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчим, хөгжлийн чиг хандлага, сэтгүүлийн нийтлэлийн бодлогод нийцсэн, бүтээлийн давхцал нь 20 хувиас ихгүй, хянан магадлагаа хийж зөвшөөрөгдсөн бүтээлийг нийтэлнэ.
- 4.2. Сэтгүүл нь дараах булантай байх бөгөөд тухайн дугаарт нийтлэх бүтээлээс хамааран булангийн цар хүрээ өөрчлөгдөж болно. Үүнд:
 - 1.2.1. Хууль төрөхийн өмнө
 - 1.2.2. Эрх зүйн сэтгэлгээ: Үзэл бодол, эргэцүүлэл
 - 1.2.3. Хуулийн хэрэгжилт, үр нөлөө
 - 1.2.4. Эрх зүйн судалгаа, тойм, үр дүн
 - 1.2.5. Мэдээ, мэдээлэл
 - 1.2.6. Шинэ бүтээлийн танилцуулга
- 4.3. Сэтгүүл нь дараах төрлийн бүтээлүүдийг хүлээж авна. Үүнд:
 - 4.3.1. Өгүүлэл;
 - 4.3.2. Судалгааны тойм;
 - 4.3.3. Шүүмж;
 - 4.3.4. Дүн шинжилгээ;
 - 4.3.5. Шинжлэх ухааны тайлбар;
- 4.4. Сэтгүүлийн нэг дугаарын нэг буланд зохиогч нэгээс илүүгүй бүтээл өгөх бөгөөд хоёр өөр буланд өөр бүтээлээ хамтад нь нийтлүүлж болно.
- 4.5. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн аливаа бүтээл нь дараах нийтлэг шаардлагыг заавал хангасан байна:
 - 4.5.1. Бүтээлийн нэр, зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй албан тушаал нь монгол, англи хэл дээр байх;
 - 4.5.2. Бүтээл нь дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:
 - Гарчиг (монгол, англи хэлээр);
 - Товчлол (монгол, англи хэлээр);
 - Түлхүүр үгс (монгол, англи хэлээр);
 - Үндсэн хэсэг;
 - Дүгнэлт, санал;
 - Эх сурвалж;
 - Хавсралт.
 - 4.5.3. Бүтээлээ ирүүлэхдээ зохиогчийн сүүлийн 1 жилд авахуулсан зураг (300-аас доошгүй нягтаршилтай, dpi, .jpg, .psd өргөтгөлтэй), цахим шуудан, холбоо барих утасны дугаарыг хавсаргасан байх;
 - 4.5.4. Бүтээлийг MS Word програмаар, ерөнхий гарчиг нь Times New Roman, 11 pt хэмжээтэй Bold, ТОМ ҮСГЭЭР, Дэд гарчгууд нь Times New Roman, 11 pt үсгийн хэмжээтэй Bold форматтай, үндсэн бичвэрийг Times New Roman, 11 pt, мөр хоорондын зай 1 (single); эшлэл, зүүлтийг Times New Roman, 10 pt, мөр хоорондын зай 1 (single) хэмжээтэй байхаар бичих бөгөөд .docx өргөтгөлөөр ирүүлэх;

- 4.5.5. Сэтгүүлийн нийтлэлд хянан магадлагаа хийлгэх хураамж 50.000 /тавин мянга/ төгрөг байна. Хянан магадлагааны хураамж төлсөн баримтыг бүтээл ирүүлэхдээ хамт хавсаргах;
 - 4.5.6. Бүтээл нь гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл, эмхэтгэл, санд өмнө нь хэвлэн нийтлэгдээгүй байх;
 - 4.5.7. Агуулгын хувьд зохиогчийн эрх зөрчөөгүй, бүтээлийн давхцал 20 хувиас ихгүй байх;
 - 4.5.8. Эшлэл, зүүлт, эх сурвалжийг энэхүү журамд заасан стандартын дагуу тэмдэглэсэн, зохиогчийн эрхийн зөрчилгүй, зүй бус хэллэг ашиглаагүй байх;
 - 4.5.9. Түлхүүр үгс нь 5 тооны холбоо нэр үгээс бүрдэх ба бүтээлийн гарчигт ороогүй үгээс бүрдсэн байна. Түлхүүр үгийг монгол болон англи хэлээр бичсэн байна.
 - 4.5.10. Товчлол нь монгол болон англи хэлээр өгүүллийн агуулгыг ойлгомжтой байдлаар хураангуйлсан нэг цогцолбор буюу 100-200 үгтэй байна. Товчлолд өгүүллийн аль нэг хэсгээс шууд хуулбарлаагүй байвал зохино.
 - 4.5.11. Үндсэн хэсэгт гадаад, дотоодын эрх зүйн онолын болон эрдэмтдийн бүтээл, тохиолдол (англ. case) ашиглан дэвшүүлсэн санаагаа илэрхийлэх, өөрийн биш санаа, өгүүлбэрт эшлэл заавал авсан байна.
 - 4.5.12. Дүгнэлт, саналыг бичихдээ Үндсэн хэсэгт дурдаагүй шинэ санаа оруулахгүй бөгөөд дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэх арга зам санал болгосон байвал зохино.
 - 4.5.13. Бүтээл хэл зүйн дүрмийн алдаагүй байх бөгөөд зохиогч алдаа шалгагч програм ашиглан алдааг хянан зассан талаар баталгаажуулах үүрэг хүлээнэ.
- 4.6. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээл нь энэ журмын 4.5-д заасан шаардлагыг эс хангасан бол сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга шаардлага хангуулахаар зохиогчид буцаах ба буцаасан тохиолдолд дахин шаардлага хангахгүй бол хүлээн авахаас татгалзана.
- 4.7. Өгүүлэл
- 4.7.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь эрх зүйн онол, практикийн тулгамдсан асуудлыг хөндсөн, хандлага зохицуулалтыг харьцуулан авч үзсэн эсхүл шийдэл эрэлхийлсэн, шинжлэх ухааны болон эрх зүйн үндэслэлтэй санал, дүгнэлт гаргасан, зохиогчийн эрхийг хүндэтгэсэн, судалгааны ач холбогдолтой байна.
 - 4.7.2. Өгүүлэл нь гарчиг, түлхүүр үгс, товчлол, эх сурвалжийн жагсаалт, хавсралтаас гадна 2500-аас доошгүй үгтэй, 7-20 хүртэлх хуудас байна.
- 4.8. Судалгааны тойм
- 4.8.1. Судалгааны тойм нь хүрээлэн болон бусад хүрээлэн, байгууллагын хууль зүйн аливаа судалгааны агуулга, үр дүнг тоймлосон байна.
 - 4.8.2. Судалгааны тойм нь 10-25 хүртэлх хуудас байна.
- 4.9. Шүүмж

- 4.9.1. Бүтээлийн шүүмжийг тухайн судлаачаас өөр судлаач бичсэн байна.
- 4.9.2. Шүүмж нь тухайн бүтээлийн хууль зүйн шинжлэх ухаанд оруулж байгаа хувь нэмрийг дурдаж, урьдах бүтээл, эрх зүйн номлол, хууль тогтоомж, эрх зүйн практик зэргийг холбож илэрхийлсэн байвал зохино.
- 4.9.3. Шүүмжлэх бүтээл нь хууль зүйн салбарын магистр, докторын судалгааны ажлаас бусад эрдэм шинжилгээний бүтээл байна.
- 4.9.4. Шүүмж нь 3000-аас дээшгүй үгтэй байна.

4.10. Дүн шинжилгээ

- 4.10.1. Дүн шинжилгээ нь шүүхийн болон арбитрын шийдвэрийг шинжлэн судалж, асуудал хөндсөн, боловсронгуй болгох шийдэл эрэлхийлсэн, судалгааны ач холбогдолтой байхыг шаардах бөгөөд хууль тогтоомжийн хэрэглээ, хянан шийдвэрлэх ажиллагаанд шинэ хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн байна.
- 4.10.2. Дүн шинжилгээ нь сэтгүүлийн нэг дугаарт салбар эрх зүй тус бүрээр дагнасан 1-ээс илүүгүй дүн шинжилгээ байна.
- 4.10.3. Дүн шинжилгээнд эрх зүйн онолын аливаа бүтээл ашигласан бол эшлэл, зүүлт заавал авна.

4.11. Шинжлэх ухааны тайлбар

- 4.11.1. Тайлбар нь хууль зүйн ойлголт, нэр томъёо, утга агуулгыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, нэг мөр ойлголт өгөхийг зорьсон байна.
- 4.11.2. Тайлбар нь 700-аас доошгүй үгтэй байна.

4.12. Эшлэл, зүүлт авах стандарт

- 4.12.1. Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийн эшлэлийг хуудасны доод талд (англ. *footnote*) үргэлжлүүлэн дугаарлах байдлаар авах бөгөөд гадаад болон дотоодын бүтээл эсэхээс үл хамааран дараах байдлаар нийтлэг эшлэл авсан байвал зохино.

4.12.2. Хууль тогтоомжийг эшлэхдээ:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэл, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn)-ээс авах бөгөөд дам эх сурвалж хэрэглэхгүй байвал зохино.

Хуулийн нэр, батлагдсан он *гэсэн дарааллыг баримтална. Жишээлбэл:*

Монгол хэл дээрх

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.

Гадаад хэл дээрх

2. The Constitution of the Republic of Korea, 1948.

Хууль тогтоомж хэсэгт хууль, эрх зүйн хэм хэмжээний актаас гадна захиргааны актыг оруулна. Мөн олон улсын конвенц, олон улсын байгууллагын шийдвэр, зөвлөмж зэргийг энэ хэсэгт оруулна.

4.12.3. Ном, сурах бичгээс эшлэхдээ

Нэг зохиогчтой бүтээлээс эшлэхдээ зохиогчийн овгийн эхний үсэг, нэр, *бүтээлийн нэр (налуу)*, хэд дэх удаагийн хэвлэл болох, хэвлэн нийтэлсэн газар,-хэвлэх үйлдвэр, хэвлэн нийтэлсэн он, хуудасны дугаар (цэг) гэсэн дараалал баримтална. Жишээлбэл,

Монгол хэл дээрх

- С.Нарангэрэл, *Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо: харьцуулсан эрх зүй*, Адмон, 2001, 98 дахь тал.

Гадаад хэл дээрх

- N.W.Alcock, *Old Title Deeds*, Chichester, Phillimore & Co.Ltd, 1986, p.32.

Хоёр болон түүнээс дээш зохиогчтой бүтээлээс эшлэхдээ хоёр зохиогчтой бол хоёулангийнх нь овгийн эхний үсэг, нэрийг, хоёроос дээш зохиогчтой бол гол зохиогчийн нэрийг бичээд “нар” (англи бол “et al”) хэмээх олон тооны нөхцөлийг залгана. Гэвч эх сурвалж хэсэгт бүх зохиолчдын нэрийг дурдаж оруулна. Зохиогчдын нэрээс бусад нь нэг зохиогчтой номоос эшлэхтэй адил байна.

Орчуулгын бүтээлээс эшлэхдээ зохиогчийн овгийн эхний үсэг, нэр, *бүтээлийн нэр (налуу)*, “орч.” (англ. trans.) гээд орчуулагчийн нэр, хэвлэн нийтэлсэн газар, хэвлэлийн байгууллага, хэвлэн нийтэлсэн он, хуудасны дугаар гэсэн дараалал баримтална. Жишээлбэл,

Монгол хэл дээрх

- Чезаре Беккариа, *Гэмт хэрэг ба ялын тухай*, орч. Г.Эрдэнэбат, ННФ, 2017, 23 дахь тал.

Гадаад хэл дээрх

- Claude Julien, *Canada: Europe's Last Chance*, trans. Penny Williams, St.Martin's Press, 1968, p.12.

4.12.4. Шүүхийн шийдвэрээс эшлэхдээ

Монгол улсын шүүхийн шийдвэрээс эшлэхдээ шүүхийн нэр, шийдвэрийн нэр /тогтоол эсхүл захирамж, шийдвэр аль нь болохыг/, шийдвэрийн дугаар, он сар өдөр, шийдвэрийн холбоос гэсэн дараалал баримтална.

- Баянзүрх дүүргийн иргэний анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 101/ШШ2021/00456, 2021.02.04, https://shuukh.mn/single_case/100684?daterange=2020/01/01%20-%202021/03/08%20&id=1&court_cat=1&bb=1.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр болон Улсын дээд шүүхийн тогтоол, зөвлөмжийг ишлэхдээ шүүхийн нэр, шийдвэрийн нэр, шийдвэрийн дугаар, он сар өдөр гэсэн дараалал баримтална.

- Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэх тухай, №7, 2015.

Гадаад улсын болон олон улсын шүүхийн шийдвэрээс эшлэхдээ дээрх дарааллыг адил баримтална.

4.12.5. Судалгааны өгүүлэл, эмхэтгэлээс эшлэхдээ

Сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллээс эшлэхдээ зохиогчийн овгийн эхний үсэг, нэр, бүтээлийн нэр (хашилтад), цувралын дугаар, нийтлэгдсэн сэтгүүлийн нэр (налуу), дугаар, он (хаалтанд), хуудасны дугаар гэсэн дарааллыг баримтална. Жишээлбэл,

Монгол хэл дээрх

- Ж.Амарсанаа, “Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц ба Монгол Улсын үндэсний хууль тогтоомж: Уялдуулах арга зам”, 56 *Хууль дээдлэх ёс сэтгүүл* №3 (2005), 70 дахь тал.

Гадаад хэл дээрх

- Henry G. Manne, “Our Two Corporation System: Law and Economics”, 53 *Virginia Law Review* 2 (1967), p.262.

Судалгааны болон эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлээс эшлэхдээ зохиогчийн нэр, бүтээлийн нэр (хашилтад), *эмхэтгэлийн нэр* (налуу), эмхэтгэлийн дугаар, хэвлэн нийтэлсэн газар, хэвлэлийн байгууллага, хэвлэн нийтэлсэн он, хуудасны дугаар гэсэн дараалал баримтална. Жишээлбэл,

Монгол хэл дээрх

- Б.Мөнхдорж, “Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалын хэрэглээ”, *Эрх зүйн шинэчлэл: зарим асуудал* (бодлогын судалгааны эмхэтгэл), Би Си Ай ХХК, 2020, 61 дэх тал.

Гадаад хэл дээрх

- Rodolfo Fiallos, “An overview of the Process of Dating Undated Medieval Charters: Latest Results and Future Developments”, in *Dating Undated Medieval Charters*, Woodbridge, Boydell Press, 2000, p.37.

Эрдмийн зэрэг горилсон эрдэм шинжилгээний бүтээл энэ хэсэгт хамаарах бөгөөд зохиогчийн нэр, бүтээлийн нэр (хашилтанд), горилсон зэрэг дипломын ажил, зэрэг олгосон сургууль, зэрэг олгосон он гэсэн дарааллыг баримтална. Жишээлбэл:

Монгол хэл дээрх

- Г.Баяраа, “Монгол Улсын хүний эрхийг хамгаалах механизм ба тулгамдсан асуудал”, докторын зэрэг горилсон бүтээл, МУИС-ХЗС, 2014.

Гадаад хэл дээрх

- James M.Diehl, “Anthropology at War: World War I and the Science of Race in Germany”, Phd. Diss, Indiana University, 2002.

4.12.6. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээс эшлэхдээ

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн цахим хуудас эшлэхдээ мэдээ (эсхүл нийтлэл, ярилцлага байж болно)-ний нэр (налуу)нэр, зохиогч эсхүл эрхлэн гаргасан байгууллагын нэр, цахим хуудсын холбоос (англ. URL), цахим хуудсыг үзсэн сүүлийн огноог бичнэ. Жишээлбэл,

- Ц.Нямсүрэн: *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх хэрэгтэй*, Medee.mn, <https://medee.mn/p/175016> , [Сүүлд үзсэн: 2023.01.28].

4.12.7. Эх сурвалжийн жагсаалт нь зөвхөн тухайн бүтээлд ашигласан бүтээлээс бүрдэх бөгөөд Монгол болон гадаад хэл дээрх эх сурвалж гэсэн үндсэн бүлэгтэй байна.

4.12.8. Бүлэг тус бүрт хамаарах бүтээлийг дараах дарааллаар ангилан жагсаасан байна. Үүнд:

- а. хууль тогтоомж
- б. ном, сурах бичиг
- в. судалгааны өгүүлэл, эмхэтгэл
- г. шүүхийн шийдвэр
- д. цахим мэдээлэл

Тав. Сэтгүүлийн хэвлэлт ба түгээлт

- 5.1. Сэтгүүлийг монгол хэлээр эрхлэн гаргах ба жилд нэг удаа англи хэл дээр дугаар гаргана.
- 5.2. Бүтээлийг сэтгүүлийн ээлжит дугаар гарахаас 50 хоногийн өмнө хүлээн авна.
- 5.3. Сэтгүүл нь улирал тутамд нэг дугаар гарах ба англи хэл дээрх дугаарын хамт жилд нийт таван дугаар гарсан байна. Сэтгүүлийн ерөнхий эрхлэгчийн зөвшөөрснөөр нэмэлтээр тусгай дугаар гаргаж болно.
- 5.4. Сэтгүүлийн англи хэл дээрх дугаарыг дөрөвдүгээр улиралд багтаан хэвлэх ба тусгай дугаарыг хэвлэхэд энэ зүйлд заасан хугацаа хамаарахгүй.
- 5.5. Сэтгүүлийн түгээлтийг хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга хариуцах бөгөөд сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга түгээлтийн жагсаалтыг улирал тутамд шинэчлэн ерөнхий эрхлэгчээр батлуулна. Түгээлтийн мэдээлэл, баримтын хуулбарыг сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн даргад хүлээлгэн өгсөн байна.

Зургаа. Сэтгүүлийн оны онцлох бүтээл

- 6.1. Сэтгүүлд нийтэлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн онол, практикийн ач холбогдлыг үнэлэх, эрдэмтэн, судлаачдыг урамшуулах зорилгоор тухайн жилийн онцлох эрдэм шинжилгээний бүтээлийг шалгаруулж болно.
- 6.2. Онцлох эрдэм шинжилгээний бүтээл нь нийтийн болон хувийн эрх зүйн салбарын асуудлыг хөндсөн тус бүр нэг, нийт хоёр бүтээл байна.
- 6.3. Онцлох бүтээлийг сэтгүүлийн эрхлэгчийн саналыг үндэслэн сэтгүүлийн ерөнхий эрхлэгч батална.
- 6.4. Шалгарсан онцлох бүтээлийн зохиогчид хүрээлэнгээс бэлэг дурсгалын зүйл, батламж олгоно.

Долоо. Сэтгүүлийн санхүүжилт

- 7.1. Сэтгүүлийн ажлын алба нь хүрээлэнгийн төсөвт үндэслэн үйл ажиллагаа явуулна.
- 7.2. Сэтгүүл нь улсын төсөв, үйл ажиллагааны орлого, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө, хууль тогтоомжоор хориглосноос бусад эх үүсвэрээс санхүүжиж, ижил чиглэлийн бусад байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллаж болно.
- 7.3. Сэтгүүлийг борлуулсны болон үйл ажиллагаанаас олох орлогыг сэтгүүлийг эрхлэн гаргахад зарцуулна.
- 7.4. Сэтгүүлийн нийтлэлийн хянан магадлагааны хураамжийг сэтгүүлийн хянан магадлагааны урамшуулалд зарцуулна. Хянан магадлагааны үр дүн ямар байхаас үл хамааран хураамжийг буцаан олгохгүй.
- 7.5. Сэтгүүлд хууль зүйн шинжлэх ухааны салбарын тодорхой салбар эрх зүйгээр өндөр мэргэшсэн, нэр хүнд бүхий эрдэмтэн, судлаач /доктороос доошгүй эрдмийн зэрэгтэй/-аар захиалгат нийтлэл хэвлэн нийтэлж болно. Захиалгат нийтлэлийн нэгж бүтээлийн хөлс 100.000 /зуун мянга/ хүртэлх төгрөг байна.
- 7.6. Сэтгүүлийн зөвлөл, ажлын албаны гүйцэтгэсэн үүрэг, оролцоог харгалзан урамшуулал олгож болно.

Найм. Сэтгүүлийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 8.1. Энэхүү журмыг сэтгүүлийн ерөнхий эрхлэгч бөгөөд хүрээлэнгийн захирлын тушаалаар батална.
- 8.2. Журамд оруулах нэмэлт, өөрчлөлт нь журмын салшгүй хэсэг байна.